



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/61

Хэрлэн сум

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.5, 32 дугаар зүйлийн 32.1, 32.1.1, 32.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2 дугаар хуралдааны аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, сум орон нутгийн гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2024 оны 02 дугаар сарын 23-аас 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрүүдэд Дархан суманд зохион байгуулсугай.

2. Тус сургуульд шаардагдах 4,155,480 (дөрвөн сая нэг зуун тавин таван мянга дөрвөн зуун наян) төгрөгийг аймгийн гамшгийн эрсдэлээс хамгаалах сангийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Иж бүрэн сургуулийг зохион байгуулах комиссыг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар, удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Дээрх арга хэмжээг тусгай удирдамж, төлөвлөгөөний дагуу сахилга хариуцлага, чанартай зохион байгуулж дүнг танилцуулахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
... дүгээр сарын ...-ны өдрийн  
... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН СУРГУУЛЬ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

- |                       |               |   |
|-----------------------|---------------|---|
| Комиссын дарга:       | Л.Батсайхан   | Аймгийн Засаг даргын орлогч   |
| Сургуулийн удирдагч:  | Ж.Эрдэнэбат   | Онцгой байдлын газрын дарга,<br>Хурандаа  |
| Нарийн бичгийн дарга: | Г.Мөнхнаран   | Онцгой байдлын хэлтсийн дарга,<br>Гамшгаас хамгаалах улсын хяналтын<br>байцаагч, Хошууч |
| Гишүүд:               | Э.Жавхлантөгс | Цагдаагийн газрын дарга, цагдаагийн<br>Хурандаа   |
|                       | Ц.Гэрэлмаа    | Зооноз өвчин судлалын төвийн дарга  |
|                       | Н.Анхбаяр     | Мал эмнэлгийн газрын дарга  |



Аймгийн Засаг даргын 2024 оны  
... дүгээр сарын ...-ны өдрийн  
... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулахад  
шаардагдах зардлын тооцоо

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль						
				Шатахууны зардал	Томилолтын зардал	Бусад зардал
1	ОБГ	Дархан сум	2024 оны 02 дугаар сарын - 23-29-ний өдөр	Чингис хот- Дархан - Чингис хот 290 км-т 52 л, дотор 50км-т 10 л нийт 62 л 156.240 төг	5 хүн 7 хоног 2.240.000 төг	Шагнал 440.000 төг, бодлогын зураг 215.000 төг, аннос 180.000 төг Нийт 835.000 төг
				Чингис хот- Дархан- Чингис хот 400 км-т 52 л, дотор 50км-т 10 л нийт 62 л 156.240 төг	Сургууль удирдах 6 хүн, 2 хоног/ 768.000 төг	
Нийт 4,155,480 төгрөг						



Аймгийн Засаг даргын 2024 оны  
..... дүгээр сарын .....-ны өдрийн  
..... дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

## **ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН СУРГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

### **Нэг: Зорилго.**

Дархан сумын гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг хангуулж тохиолдож болзошгүй ой, хээрийн болон объектын гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, байгаль, цаг уурын гаралтай гамшгийн үед хариу арга хэмжээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулах, сумын шуурхай штаб, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, иргэдийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулж мэдлэг, чадвар олгоход чиглэгдэнэ.

### **Хоёр: Сургалтад хамрагдах сум, зохион байгуулах хугацаа.**

Гамшгаас хамгаалах Иж бүрэн сургуулийг Дархан суманд 2024 оны 02 дугаар сарын 23-аас 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрүүдэд зохион байгуулна.

### **Гурав: Зохион байгуулах ажил.**

- Бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангах.
- Сургалт зохион байгуулах байр танхимыг бэлтгэх.
- Шуурхай штаб, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг шалгаж хүн нэг бүрийн үүргэвчид үзлэг хийх.
- Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн техник хэрэгсэл багаж хэрэгслийг шалгах.
- Тус сумын иргэдийг иж бүрэн сургуульд идэвхтэй оролцуулах зохион байгуулсан нөлөөллийн ажил үнэлэх.
- Учирч болзошгүй гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх хариу арга хэмжээнд иргэдийн оролцоог дүгнэх
- Сумын Мэргэжлийн анги гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр бүтээлч ажил орон нутагт зохион байгуулах.
- Онцгой комисс, бие бүрэлдэхүүнийг 1 дүгээр цагийн байдал дээр ажиллуулах.
- Онцгой комисс, бие бүрэлдэхүүнийг 2 дугаар цагийн байдал дээр ажиллуулах.
- Онцгой комисс, бие бүрэлдэхүүнийг 3 дугаар цагийн байдал дээр ажиллуулах.
- Команд штабын сургуулийг дүгнэх, хаах.

### **Дөрөв: Сургуулийн бэлтгэл ажил хангах ажлыг хэсэг:**

Ажлын хэсгийн ахлагч:	Г.Мөнхнаран	Онцгой байдлын хэлтсийн дарга, Гамшгаас хамгаалах Улсын хяналтын байцаагч, Хошууч
Гишүүд:	Ч.Гантогтох	Эрэн хайх аврах салбарын Захирагч, Хошууч
	Г.Золжавхлан	Ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, Ахмад
	Ч.Болорчимэг	Ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, Дэслэгч
	Д.Оюунбаатар	Шуурхай албаны жолооч, Ахлах ахлагч

**Тав:Дүнгийн талаар**

Иж бүрэн сургуулийг зохион байгуулсан дүнг илтгэх хуудсаар бичиж аймгийн Засаг дарга, Онцгой комиссын хуралдаанд танилцуулах, цаашид анхаарах, зөрчил дутагдлыг засаж арилгах талаар зөвлөмж, үүрэг даалгавар өгөх.